



ОЮУТНЫ ХӨГЖИЛ, ТӨЛӨВШЛИЙН АСУУДАЛД

А.Оюунбилэг, Г.Батжаргал магистр
МУБИС-ийн СӨБСС-ийн СХУСС-ын тэнхимийн багш

Резюме: Одной из форм работ, осуществляемых в учебной практике МГУО в сфере реформы высшего образования, является предоставление самим студентам свободы /права/ выбора преподавателя и учебных дисциплин. В связи с внедрением балльно-рейтинговой системы образуются многочисленные группы и студенты занимаются по академической группе по каждой выбранной дисциплине, так и не успев ближе познакомиться друг с другом. Согласно возрастной периодизации, поступившие в вуз студенты находятся в юношеском возрасте. Занимая особое место в процессе развития и формирования личности, юношеский возраст является своеобразным переходным периодом влечёт за собой крутые изменения, новые комплексы, иногда противоречие и кризис в их физическом, познавательном и социальном сфере. С другой стороны, студенческий возраст характеризуется периодом огромных желаний участия в общественных мероприятиях, открытия многосторонних способностей, укрепления своих позиций в коллективе, испытания себя, творческого отношения ко всему, формирования у себя самоуверенности и т.д, и т.п.. Целью данного исследования является выявление — сплоченности, совместной ответственности, наличия времени для организации предметной деятельности студенческой академической группы.

Түлхүүр үг: Хамт олон, орь залуу нас, төлөвшил, зөвлөх багш

Удиртгал

Оюутны нийгэмшихүйн хөгжилд

сургалтын зохион байгуулалт, бүлэг хамт олны нөлөөллийг тандах зорилго бүхий бичил судалгааг МУБИС-ийн Багшийн сургуулийн СӨБСС-д 2014-2015 оны хичээлийн жилд элссэн 256 нэгдүгээр курсын оюутнуудын 75%-ийг хамруулан асуулгын аргаар явуулж, боловсруулалтыг SPSS програм дээр гүйцэтгэлээ.

Их, дээд сургууль нь оюутанд хүний хөгжлийн үнэт зүйлсийн талаарх ойлголт, нийгмийн талаарх мэдлэг туршлагыг баяжуулан, цогц чадамжтай бие хүн, мэргэжилтэн бэлтгэх үүрэг зорилготой. Шинээр элссэн оюутнуудын суралцах хугацааны явцаас ажиглахад тэдний сурах арга барил, аливаад хандах хандлага, сэтгэхүйн цар хүрээ, үүрэг хариуцлага хүлээх чадвар зэрэг төлөвшлийн асуудал нь анхаарал татаж байна. Оюутан их, дээд сургуульд элсэн орсноор “тодорхой хамт олны бүлэгт харъяалагдан шинэ орчин нөхцөлтэй танилцах, суралцах үйл ажиллагаандаа дасан зохицох, зорилго чиглэлээ ухамсарлах, хамтарч сурч хөгжих хэрэгцээ бий болдог бөгөөд энэ насанд цөөнгүй бэрхшээл оюутны өмнө тулгардаг. Учир нь “шинээр бүрэлдсэн хамт олон сургуулийн дүрэм, журам, хэм хэмжээ, уламжлалыг мэдэхгүйгээс олон бэрхшээлийг даван туулах шаардлага урган гардаг” (Мягмар, 2009). Шинээр элссэн оюутнуудын хамтын бүлэг бүрэлдэн тогтсоноор тэдний үзэл бодол төлөвшиж, олон талт харилцаа үүсч эрхэмлэх үнэт зүйл бүрэлдэн ирээдүйн багш мэргэжил эзэмших суурь болдгийг эрдэмтэд судлан тогтоосон байна.

Бидний судалгаанд сургалтын зохион байгуулалт нь оюутны хамт олны бүрдэлт, тэдний үйл ажиллагааны оролцоонд хэрхэн

нөлөөлж буйг илрүүлэх зорилго бүхий тоон үнэлгээгээр үнэлэгдэх 8, чанарын үнэлгээгээр үнэлэгдэх 2 асуулттай асуулгаар судалгааг явууллаа.

Үндсэн хэсэг

Шинжлэх ухаан, мэдээллийн салбарт болон амьдралд гарч буй өөрчлөлт нь хүн бүрээс өргөн мэдлэг, өндөр чадвар, эрүүл харилцаа, зөв хандлага, бүтээлч сэтгэлгээг шаардаж байгаа нь мэргэшлийн хувьд чадварлаг, ёс зүйтэй багш бэлтгэхийг шаардах боллоо. Ялангуяа хүний хөгжил төлөвшлийн суурь бүрэлдэж улмаар цаашдын хөгжилд нөлөөллөө үзүүлдэг бага насны хүүхэдтэй ажиллах багшийн хөгжил, төлөвшил чухал байгаа. Энэ насны хүүхэд багшийн зохион байгуулж буй үйл ажиллагаа, харилцаа, биеэ авч яваа байдал, аливаад хандах хандлага, бүтээлч чадвараас шууд даган дуурайж хөгждөг. Иймд бидэнд цэцэрлэгийн багшийн хөгжлийн чанарыг дээшлүүлэхэд шинээр элсэн орж буй оюутны хөгжил төлөвшилд цогцоор хандаж түүнд нөлөөлөх олон хүчин зүйлийг тогтоох, эрэмбэлэн шийдвэрлэх арга замыг тодорхойлох шаардлага зүй ёсоор гарч байна.

Эрдэмтэд дээд боловсролтой мэргэжилтний чанарыг дээшлүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа хийсээр байна. Жишээ нь, 2008-2009, 2009-2010 оны хичээлийн жилд ШУТИС-д элсэн орсон оюутнуудаас 4 төрлийн хичээлийн ЭЕШ-ын гүйцэтгэлд судалгаа хийн инженерийн боловсрол олгох сургалтын чанар муу байгаагийн гол шалтгаан нь элсэгчдийн боловсролын түвшин хангалтгүй, сурахуйд сурах чадамж-чадвар ихээхэн дутагдалтай, мэдээлэл хүлээн авах сэтгэлзүйн бэлтгэл болон тэсвэр тэвчээр, анхаарлаа төвлөрүүлэх, хариуцлагаа ухамсарлах чадвар дутуу төлөвшсөн байна гэж дүгнэжээ. (Алтансүх нар, 2010) Судалгааны энэ дүгнэлт элсэгчдийн хувь хүний хөгжлийг сайжруулахад чиглэсэн ажлыг тэдний хэрэгцээ сонирхолд нийцүүлэн зохион байгуулах шаардлага байгааг харуулж байна.

Ирээдүйн багш болох оюутан хичээл, хичээлээс гадуурх ажилд хэр оролцоно тэр хэмжээгээр өөрийгөө нээж, оюуны олон талын чадвараа хөгжүүлж, өөртөө итгэлтэй, харилцааны зөв дадалтай болж багш - бие хүний төлөвшлийг олж байдаг. Судлаач Н.Цогзолмаа (2013) оюутан хичээлээс гадуурх ажилд оролцох оролцооны ажлын талаар хэр зэрэг ойлголцоттой байна, мөн энэ ажилд хэр ач холбогдол өгч оролцдог талаар хийсэн судалгааны дүгнэлтдээ: “Оюутнууд хичээлээс гадуурх ажилд оролцох оролцооны ажил нь оюутан-багшийн хөгжил төлөвшилд ихээхэн нөлөөтэй гэдгийг мэддэг боловч яаж оролцохоо мэддэггүй. Энэ үйл ажиллагаанд оролцоход мөнгө санхүү хэрэгтэй ч өөрийн зүтгэл, сонирхол, авьяас, хандлагаар оролцож болдог олон ажил байдаг тухай оюутанд сурталчилах, ойлгуулах, зохион байгуулах шаардлагатай гэсэн байна.

Энэ нь оюутан аливаа үйл ажиллагаанд оролцохын хэрээр хөгжиж, төлөвшин, хөгжиж төлөвшихийн хэрээр чадваржин аливаад хандах хандлагыг олж ирээдүйн чадварлаг мэргэжилтний суурь тавигддаг гэдгийг тэдэнд ойлгуулах арга зүй, тусалцаа дэмжлэг хэрэгтэйг үзүүлж байна.

Мөн ЕБС-ийн сургуулийн орчин дахь хичээлээс гадуурх сургалтын ажилд сурагчдын оролцоо, түүнд хийсэн шинжилгээ судалгааны дүгнэлтэнд (Баярцэцэг нар, 2013) “Сурагчид нийгмийн дүрэм, журамд хандах талаар эерэг хандлага төдийлөн илрээгүй ба энэ нь анхаарал татаж байна. Тухайн сурагч нийгэмшин хөгжиж буйг илэрхийлэх хандлагын талаар авч үзэх шаардлага бийгэдгийг үүгээр сануулж байна” гэж дүгнэсэн нь цаашид их, дээд сургуульд суралцагсдын сурах арга барил, асуудал шийдвэрлэх, бэрхшээлийг даван туулах, сэтгэл зүйн үндсэн чадварыг хөгжүүлэх, нийгэмшихүй, ёс зүйн төлөвшилд хандсан ажил зохион байгуулах хэрэгцээ урган гарч байгааг илтгэж байна.

Судлаач Х.Гүндсамбуу оюутнуудын нийгмийн байр суурийг “...завсрын, дундын, шилжимтгий байр сууринд байдаг.



Энэ завсрын шилжимтгий торгон мөчид бие хүний ямар шинж хэрхэн бүрэлдэн төлөвшихөөс цаашдынх нь хувь заяа нэлээд хэмжээгээр хамаарна” гэж дүгнэсэн байна. Багш бие хүний хөгжил төлөвшил олон талт хүчин зүйлийн нөлөөллөөс хамардаг цогц асуудал болох нь дээрх судалгаануудаас харагдаж байгаа ба бид зөвхөн оюутны хичээл сонголт, хамт олны бүрдэлтийн талаарх асуудлыг судалгаагаараа хөндөхийг зорилоо.


Хамт олон гэдэг нь өөрийн бүтэц зохион байгуулалт, гүйцэтгэх үүргээрээ нийгмийн бүхий л харилцааг өөртөө шингээж байдаг нэгдмэл зорилго, үйл ажиллагаатай, харилцан бие биендээ туслах, суралцах хамтын үйл ажиллагааны нэгдмэл харилцаа давамгайлсан хэсэг бүлэг хүмүүс юм. Хамт олны гишүүн байна гэдэг нь хамт олны нэгдмэл зорилго, үйл ажиллагаан доор өөрт байгаа бүхий л боломжоо дээд зэргээр дайчилж, юу хийж чаддагаа харуулж хамт олон дотроо өөрийн гэсэн орон зай, байр суурийг эзэлсэн хүнийг ойлгодог. (Доржжав, 2007)

Их сургуулийн сургалтын эхний нэг жил оюутанд ангийн хамт олон, удирдан чиглүүлж, үлгэрлэн дагуулах багшийн нөлөөлөл, сургалтын ажлын зохион байгуулалт чухал байдаг.

Бидний судалгаанд 174 оюутан хамрагдсан ба энэ нь СӨБССургуулийн нэгдүгээр курсын оюутнуудын 75%-ийг эзэлж байна.

Диаграмм 1

Судалгаанд оролцсон оюутны нас




Диаграммаас харахад судалгаанд хамрагдсан нэгдүгээр курсын нийт оюутны 52% нь 16-18, 47% нь 19-21 насны оюутнууд

байна. Сэтгэл судлаач Эрик Эриксон хүний хөгжлийн 18-22 нас буюу оюутан ахуй насны зөрчил зохистой шийдвэрлэгдвэл залуучууд өөрийн “Би”-гээ сайтар ойлгож, харин шийдвэрлэгдэж чадаагүй бол гүйцэтгэх ёстой олон үүргүүд нь холилдон “Би ойлголт саринадаг гэсэн онолын насны ангилалд байна. Энэ насанд бие хүний үндсэн бүрдэл буюу зан төлөв, чиг хандлага, ертөнцийг үзэх үзэл, өөрийн ухамсар, хэрэгцээ сонирхол тогтворжин, өөрийгөө шинжин таньж илэрхийлэх эрмэлзлэл, чадвартай болдог.

Диаграмм 2


Оюутны харьяалал



Судалгаанд хамрагдсан оюутны 55% нь Улаанбаатар хот, 45% нь орон нутгаас элссэн оюутнууд байна. Эндээс харахад орон нутаг, хотоос элссэн оюутнуудын тоо харьцангуй тэнцүү байгаа учраас энэ нь харилцан бие биенээсээ суралцах нийгэмшихэд чухал нөлөөтэй. Олон газар, орчноос ирсэн мэдлэг, чадвар, хандлага, харилцаа, соёлын ялгаатай оюутнууд нэг бүлэг болж хамт олон бүрдэхэд багагүй хугацаа шаардагдана.

Диаграмм 3

Оюутны хамрагддаг бүлгийн тоо




2014-2015 оны хичээлийн жилд элссэн оюутнууд үзэх хичээлийн цаг, зохион байгуулах багшаа сонгон судалсан байна. Сонголтыг хийх явцад нийт оюутны 63 %

нь 4-6 бүлэгт, 22,4% нь 7-9 бүлэгт хамрагдаж хичээлүүдийг үзсэн байна. Олон бүлэгт харьяалагдаж буй байдал нь оюутнууд хоорондоо танилцах, хамтарч хичээл хийх, харилцаа үүсч хамт олон бүрэлдэх, үйл ажиллагаанд хамтран оролцох зэрэг боломж нөхцөл хязгаарлагдаж нийгэмшихүйн хөгжилд нөлөөлнө гэж үзэж байна. АНУ-ын эрдэмтэн Жеймс Коулман Троу нар суралцагчдын бие хүний төлөвшилд нийгмийн бичил бүлэг ялангуяа үе тэнгийнхэн онцгой үүрэг гүйцэтгэдэг гэж үзсэний дагуу зөвлөх багшийн удирдаж буй бүлгийн нөлөөллийг нэмэгдүүлэх явдал чухал байна.

Диаграмм 4.

Оюутны хичээлийн хуваарь

Оюутны сонголтын дагуу зохион байгуулагдаж буй хичээлийн хуваарийг харахад 51,7%



нь пүрэв гараг, 32,2% баасан гаригт орохоор хичээлүүдийг нягтруулан сонгосон байгаа нь долоо хоногт жигд ачаалалтай байх ерөнхий зарчим алдагдсан байна. Оюутнууд хичээлээ багшийн цагт тохируулан, оюутны тоо гүйцээгүй тохиолдолд сонгосон ба мөн хичээлийг цөөн хоногт багтаах зорилго тавьсан тухайгаа бичсэн байлаа.


Судалгаанд хамрагдсан оюутнууд долоо хоногийн Даваа болон Мягмар гаригт хичээл сонголтыг бага хийсэн байна. Энэ

тохиолдолд Пүрэв, Баасан гарагийн ачаалал ихсэж хичээлийн чанар, оюутны оролцоо муудаж ядрах, орой тарах зэрэг сөрөг үзэгдлүүд гардаг.

Диаграмм 5

Хичээл эхлэх хугацаа

Диаграммаас харахад оюутнуудын 89,7% нь нэгдүгээр цагаас хичээл эхлэж, эрт тарж



байгаа нь өөрийгөө хөгжүүлэх, номын санд суух, бие даалтын ажил гүйцэтгэх зэрэг боломжтой давуу байдал харагдаж байна. Энэ нь бидний судалгаанд хамрагдсан оюутны хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцох боломжийг илрүүлэх зорилго бүхий асуулгад оюутнуудын 62,2% нь үйл ажиллагаанд оролцох боломжтой гэсэн дүгнэлттэй тохирч байна.

Диаграмм 6.

Тогтвортой бүлэгт харьяалагдахгүй байхын сул тал






Тогтвортой бүлэгт харьяалагдахгүй байх болон хичээллэх бүлэг, зөвлөх багшаар удирдуулсан хамт олныг анги, бүлэг хамт олон гэж үзэхгүй байгаа байдал ажиглагдаж байлаа.

Судалгаагаар олон бүлэгт харьяалагдах нь ямар нөлөөтэй байгааг судалгаанд оролцогчдын 37% нь хамт олон бүрэлдэхэд боломж муутай, 35% нь мэдээ мэдээллээс хоцордог, 28% нь эмх замбараагүй, 26% нь олон нийтийн ажлаас хоцордог, 26% найз нөхөд бага нийтэч биш гэх мэтчилэн 12 асуудлыг хөндөж тавьсан нь багш бие хүн төлөвших, хамтарч ажиллаж харилцан суралцах, зорилго, чиглэлээ ухамсарлан хөгжихөд сөрөг нөлөөтэй байх магадлалтай байна.

Диаграмм 7


Оюутны хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцох боломж



Мөн хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцох боломжтой эсэх талаарх асуултад 62.6% нь боломжтой, 36.4% нь боломжгүй гэж хариулсан байна. Үйл ажиллагаанд хамрагдсан байдлын давтамжийн дундаж нь 1-3 удаа байгаа нь учир дутагдалтай. Оюутан багшийн хөгжил төлөвшил, хамт олны бүрдэлтэнд багш нарын зөв үлгэр дуурайлал, сургуулийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа сургалт-хүмүүжлийн үйл ажиллагааны нөлөөлөл чухал хэмээн (Ц.Сумьяа нар.2012) дүгнэж үзвэл оюутнуудын хичээлээс гадуурх үйл ажиллагааны оролцоо бага нэгдүгээр курсын оюутанд зориулсан үйл ажиллагаа төдийлөн зохион байгуулагдаагүйн дээр оролцох цаг хугацаа зарим оюутанд хомс байсан байна.

Диаграмм 8

Оюутны мэдээлэл авах эх сурвалж



Сургалт, болон бусад үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хаанаас авдаг талаарх асуултад судалгаанд оролцсон оюутнуудын 32.2% нь зөвлөх багшаас, 45.4% нь сурталчилгааны самбараас, 40% нь интернет, 54.6% нь бусдаас гэсэн хариултыг өгчээ.

Оюутнууд мэдээллийн дийлэнхийг бусдаас ам дамжсан байдлаар авч байгаа нь мэдээлэл төөрөх, асуудалд эргэлзээ төрж бухимдах, багш, сургуульдаа сэтгэл ханамж дундуур байх, үл ойлголцох асуудал үүсэх талтайг давхар харуулж байна.

Хичээллэх бүлгүүд өөр өөр боловч тодорхой хамт олныг нэг багш хариуцан зөвлөх багшаар ажилладаг. Зөвлөх багшийн үүрэг оролцоог оюутнууд дараах байдлаар үнэлж байна.

№	Асуулт	Хувь
1	Зөвлөх багш биднийг чиглүүлж, зөвлөн туслаж мэдээлэл сайн өгдөг	34
2	Хааяа уулздаг, дэмжлэг, тусалцаа дунд зэрэг оюутан болгонд хүрч ажиллаж чаддаггүй	13,7
3	Зөвлөх багшийн тусалцаа дэмжлэг муу, оюутантай тулж ажиллаж, хамт олныг бүрдүүлж ажиллаж чаддаггүй	42
4	Зөвлөх багшийн үйл ажиллагаанд хариулт өгөөгүй	10,3

Судалгаанд хамрагдсан оюутнуудын 66% нь сэтгэл ханамж дундуур байгаа нь зөвлөх багш нар оюутны хэрэгцээнд нийцүүлж, ойр дотно хандаж, хөгжил төлөвшилд нөлөө үзүүлж, хамт олныг бүрдүүлж, тулгамдсан асуудлыг шийдэхэд дорвитой нөлөө үзүүлж чадахгүй байгааг харуулж байна.

Судалгааны үр дүн

1. Оюутан ахуй цаг багш - бие хүний хөгжил төлөвшилд чухал байр суурь эзэлдэг бөгөөд цаашлаад нийгмийн хөгжил, хойч үеийнхний бүх талын хөгжлийг тодорхойлогч гол хүч болдог. Энэ насанд бие хүний зан төлөв, чиг хандлага, ертөнцийг үзэх үзэл, өөрийн ухамсар, хэрэгцээ, сонирхол тогтворжин, өөрийгөө шинжин таньж, илэрхийлэх эрмэлзлэлтэй болдог (Одончимэг, 2015). Тэдний хөгжил төлөвшилд олон хүчин зүйл нөлөөлдөг ба тэдгээрийг эрэмблэн судлаж шийдвэрлэх нь чанартай багш бэлтгэх үндэс юм.
2. Хамт олныг бүрдүүлэхэд тэр дундаа шинээр элссэн оюутнуудыг нийгэмшүүлэхэд хөтөлбөрийн алба, оюутны зөвлөл, оюутанд туслах ажилтан, зөвлөх багш нар тэдэнтэй оролцооны олон хэлбэрийг ашиглан нийгмийн идэвхийг бий болгох оюутантай ажиллах арга барил, харилцаа хандлагаа цаг үетэйгээ нийцүүлэн сайжруулах хэрэгцээтэй байна.
3. Нэгдүгээр курсын оюутнуудын хичээллэх өдрөө сонгох, хичээлийн ачаалал, хөдөлмөр зохион байгуулалтыг шинжлэх ухааны үндэстэй хийхэд удирдамж чиглэлээр хангах оюутанд хөтөч болохуйц гарын авлага, зөвлөмж хэрэгтэй байна.
4. Оюутны хичээл үйл ажиллагааны оролцоо, аливаад хандах хандлага, нийгмийн идэвх, багш- бие хүн төлөвших, ёс зүйн асуудлыг эхний жилээс ойлгуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

Гүндсамбуу, Х. (2002). *Монголын нийгмийн давхраажил: хөгжил хандлага*. Улаанбаатар

Мягмар, О. (2009). *Судлаач багшийн гарын авлага*. Монгол: “Ган принт” ХХК

Одончимэг, Т. (2015). *Өнөөгийн оюутны төлөвшлийн хэв шинж*. Лавай. Улаанбаатар

Сарантуяа, Г. (2015). *Сэтгэл судлалын шинжлэх ухааны судалгааны аргууд*. Улаанбаатар: “Жиком пресс” ХХК

Уранцэцэг, Л. Дэлгэржав, М. (2012). *Нийгмийн сэтгэл судлал*. Улаанбаатар: МУИС.Хэвлэх үйлдвэр

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Батсайхан, Б., Дэлгэржав, М. (2013). *Сэтгэл судлалын бага тайлбар толь*. Монгол: “Соёмбо принтинг”
- “Боловсрол судлал” (2013/01). Улаанбаатар: Соёмбо принтинг
- Гамезо, М.В., Домашенко И. А. (1986). *Сэтгэл судлалын атлас*. Москва: Просвещение